

Япон Улсын иргэний процессын эрх зүй дэх урьдчилсан хэлэлцүүлгийн хөгжил ба сайн туршлага

Эрдэнэбаатарын ЭРХБИЛГҮҮН*

-
- I. Оршил
 - II. Япон Улсын урьдчилсан хэлэлцүүлгийн эрх зүйн зохицуулалтын хөгжил
 - 2.1 1996 оноос өмнөх урьдчилсан хэлэлцүүлэг
 - 2.2 1996 оноос хойших урьдчилсан хэлэлцүүлэг
 - III. Япон Улсыг сайн туршлага болгох нь
 - IV. Дүгнэлт
-



* Шүүхийн академийн Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн секторын эрхлэгч, хууль зүйн магистр (LL.M)



Япон улсын иргэний процессын эрх зүй дэх урьдчилсан хэлэлцүүлгийн хөгжил ба сайн туршлага

Эрдэнэбаатарын ЭРХБИЛГҮҮН Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн Үндсэн хуулийн болон олон улсын эрх зүйн секторын эрхлэгч, Хууль зүйн магистр (LL.M).

Хураангуй: Энэхүү өгүүллийн хүрээнд манай улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэхэд анхаарах зарим асуудлыг тодруулах зорилгоор Япон Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нэг үе шат болох урьдчилсан хэлэлцүүлгийн түүхэн хөгжил, эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн. Тухайлбал, тус улс нь иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралыг бууруулах зорилгоор 1925 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд анх удаа урьдчилсан хэлэлцүүлгийг хуульчилсан түүхтэй. Урьдчилсан хэлэлцүүлгийн үр нөлөөг сайжруулах зорилгоор уг хуульд 1948, 1950, 1956 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулж байсан боловч үр дүнтэй болж чадаагүй.

Харин 1996 онд шинээр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар маргааны зүйлд төвлөрсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгосон бөгөөд үүний цөм нь урьдчилсан хэлэлцүүлэг болсон. Шинэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш тус улс дахь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал тодорхой хэмжээнд буурсан. Түүнчлэн 2022 оны нэмэлт, өөрчлөлтөөр цахим хэлбэрээр урьдчилсан хэлэлцүүлэг явагдах боломжтой болж, урьдчилсан хэлэлцүүлэгт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор практик шинэчлэл явагдаж байна.

Түлхүүр үг

Маргааны зүйл, ач холбогдолтой нотлох баримт, социал процессын хууль, маргааны зүйлд төвлөрсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, нотлох баримт шинжлэн судлах

I. ОРШИЛ

Манай улсад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал тулгамдсан асуудал болоод удаж байна. Үүнд олон хүчин зүйлс нөлөө үзүүлж байгаа¹ хэдий ч тэдгээрээс шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах нь голлох шалтгааны нэг юм. Шүүх хуралдаан хойшлолттой холбоотойгоор хийгдсэн

¹ Жишээлбэл хариуцагчийн хаяг тодорхой бус, нэг шүүгчид оногдох хэргийн тоо хэт их гэх мэт.



судалгаа² болон Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргадаг хэргийн удирдлагын мэдээнээс³ үзэхэд дийлэнх тохиолдолд хэргийн оролцогч нараас шалтгаалан шүүх хуралдаан хойшилж байна. Түүнчлэн, хэргийн оролцогчид ихэвчлэн шүүх хуралдааны үеэр шинээр тайлбар, нотлох баримт гаргах, шүүх хуралдаан давхцах, шинээр итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл өмгөөлөгчтэй болох, тэдгээрийг солих гэх мэт шалтгааны улмаас шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргадаг. Харин шүүхийн зүгээс ихэвчлэн шинээр нотлох баримт бүрдүүлэх зорилгоор шүүх хуралдааныг хойшлуулах шаардлагатай болдог.

Эдгээрээс хэрэгт хамааралтай тайлбар, нотлох баримт хангалттай бүрдээгүйн улмаас шүүх хуралдаан хойшлох нь нийтлэг бөгөөд зарим судалгаанд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийн журмыг нэвтрүүлснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал буурах тухай онцолсон байдаг.⁴ Урьдчилсан хэлэлцүүлгийн талаар өмнө нь хийсэн судалгаануудыг дурдвал Шүүхийн академи "Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх харьцуулсан судалгаа"⁵, Хууль зүйн үндэсний хүрээлэн "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ"⁶, Н.Норовсамбуу, Б.Хонгорзул "Улсын дээд шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэлд хийсэн дүн шинжилгээ", Б.Хонгорзул "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэх нь"⁷ зэрэг бөгөөд тэдгээр нь 1996 онд батлагдсан Япон Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль дахь урьдчилсан хэлэлцүүлгийн эрх зүйн зохицуулалт болон үүнтэй холбогдох зарим зохицуулалт, практикт үүссэн зарим асуудлыг тодорхой хэмжээнд дурдсан байдаг.

Энэхүү судалгаа нь дээрх судалгаануудтай нэгэн адил Япон Улсын иргэний процессын эрх зүй дэх урьдчилсан хэлэлцүүлгийн тухай авч үзнэ. Гэвч ялгаатай нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиас өмнөх урьдчилсан хэлэлцүүлгийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж байсан асуудал зэргийг авч үзнэ. Түүнчлэн, 1996 оноос

² Бат-Эрдэнийн Баянхишиг, Э.Отгонзул зэрэг, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: хэргийн оролцогчийн эрх ба иргэний хэргийн хойшлолт", <https://legaldata.mn/b/827> 2019, (Сүүлд үзсэн:2026.03.04).

Монгол Улсын дээд шүүх, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хугацаа хэтэрсэн болон түдгэлзүүлсэн хэргийн судалгааны тойм", https://supremecourt.mn/media/files/20220/0_1642583446.pdf, 2019, (Сүүлд үзсэн:2026.03.04).

³ 2026.03.04-ны байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нийт 60 удаа "Хэргийн удирдлагын мэдээ" гаргасан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.judcouncil.mn/site/news/1?keyword=&page=3>-с үзнэ үү.

⁴ Нямсүрэнгийн Норовсамбуу Б.Хонгорзул, "Улсын дээд шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэлд хийсэн дүн шинжилгээ" Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ (4), 2020, 70 дахь тал.

⁵ Шүүхийн академи "Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх харьцуулсан судалгаа", <https://legaldata.mn/b/2545>, 2022, (Сүүлд үзсэн:2026.03.04).

⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ", <https://sudalгаа.gov.mn/ddDrTh>, 2021, (Сүүлд үзсэн:2026.03.04).

⁷ Б.Хонгорзул "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэх нь" <https://legaldata.mn/b/745>, 2018, (Сүүлд үзсэн:2026.03.04).



хойш урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотойгоор тус улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, практикт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээ хэрэгжүүлж байгаа талаар судална. Ийнхүү тус улсыг онол, практикийн түвшинд харьцуулан судалсны үндсэн дээр манай улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэхэд цаашид анхаарах зарим асуудлыг дэвшүүлэх болно.

II. ЯПОН УЛСЫН УРЬДЧИЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХӨГЖИЛ

2.1. 1996 оноос өмнөх урьдчилсан хэлэлцүүлэг

Энэхүү хэсэгт одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдахаас өмнөх 1890 оны болон 1925 оны хуульд заасан урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалт, мөн тулгамдаж байсан асуудлын талаар судлах болно.

2.1.1. 1890 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа

Япон Улс 1877 онд батлагдсан Германы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг загвар болгон 1890 онд анхны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиа баталсан түүхтэй.⁸ Уг хуулийг Мэйжигийн⁹ үеийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль гэж нэрлэдэг.

Тус хуулийн 208 дугаар¹⁰ зүйл ба 266 зүйлд¹¹ зааснаар тодорхой төрлийн хэрэг, маргаанд шүүхийн бэлтгэл ажиллагаа явуулах боловч, явуулах эсэх нь шүүгчийн бүрэн эрхэд хамаардаг байсан.¹² Тухайн үеийн шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа нь хэргийн оролцогч нар шүүхэд тайлбар, нотлох баримт шүүхэд гаргаж өгөхөөр хязгаарлагдаж байв.¹³

Зарим шүүгчид шүүх хуралдааны бэлтгэл хангагдаагүй тухай хэргийн оролцогчид сануулах явдал байсан боловч, дийлэнхдээ хэргийн оролцогчид

⁸ Япон Улсын анхны Үндсэн хууль нь тухайн үеийн Германы Үндсэн хуулийг загвар болгон батлагдсанаас хойш тус улсад Германы эрх зүйн нөлөө хүчтэй болж эхэлсэн. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн анхны төслийг 1883 онд Францын эрдэмтэн Гюстав Эмиль Буассонад (Gustave Émile Boissonade) боловсруулсан боловч, тухайн үедээ орчин үеийн гэж хэлэгдэж байсан Германы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг загвараа болгосон. Гэхдээ Францын хуулийг загвар болгон боловсруулсан төслийн зарим хэсэг тусгагдсан. Жишээ нь нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл прокурор төрийг төлөөлөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөөр оролцох.

⁹ Мэйжигийн үе гэдэг нь 1868 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс 1912 оны 7 дугаар сар хүртэлх хугацааг хэлнэ.

¹⁰ 208 дугаар зүйл "Шүүх тооцооны хэрэг, хөрөнгө хуваах болон үүнтэй төстэй хэрэгт шүүхийн бэлтгэл ажиллагаа явуулж болно. Гэхдээ хэрэв нэхэмжлэлийн эсрэг харуу тайлбар гаргах бол, харуу тайлбар хийгдсэний дараа бэлтгэл ажиллагаа явуулж болно".

¹¹ 266 дугаар зүйл "Тооцооны зөв буруу, хөрөнгө хуваах болон үүнтэй төстэй хэрэгт нэхэмжлэлийн шаардлага болон харуу эсэргүүцэл их байгаа тохиолдолд бэлтгэл ажиллагаа явуулж болно".

¹² 三ヶ月章「わが国の準備手続制度の問題点」『民事訴訟法研究〈第三卷〉』（有斐閣・1966年）192頁～193頁。

¹³ 林屋礼二『明治期民事裁判の近代化』（東北大学出版会・2006年）451頁。



шүүх хуралдааны үед шинээр тайлбар хүсэлт, нотлох баримт гаргаснаар шүүх хуралдаан хойшилж, улмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах болсон.¹⁴ Үүний суурь шалтгаан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талуудад бүрэн даатгаж, шүүхийн оролцоог үгүйсгэдэг иргэний процессын эрх зүйн либерал зарчмаас үүдэлтэй гэж үздэг.¹⁵

2.1.2. 1925 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилсан хэлэлцүүлэг

1925 онд шинээр батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн гол зорилго нь шүүх хэрэгт хамаарах бодит үйл баримтыг тогтооход хүчин чармайлт гаргах тогтолцоог бий болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралыг бууруулах явдал байсан.¹⁶

а. Дэлхийн хоёрдугаар дайнаас өмнөх үеийн зохицуулалт

1925 оны хуулийн хүрээнд дараах чухал өөрчлөлтүүд хийгдсэн.¹⁷ Нэгдүгээрт, анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хэрэг, маргаан бүрд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах (249-р18 зүйлээс 255 -р зүйл хүртэл)-аар болсон. Хоёрдугаарт, талууд тохиролцон шүүх хуралдааны товыг өөрчлөх явдлыг зогсоосон. Гуравдугаарт хугацаа хоцорсон тайлбар хүсэлт, нотлох баримтыг хүлээн авахаас татгалзах эрхийг шүүхэд олгосон (139 дүгээр зүйл19). Дөрөвдүгээрт, шүүх өөрийн санаачилгаар нотлох баримт цуглуулж, шинжлэн судлах боломжтой болсон. Эдгээрээс анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хэрэг маргаан бүрд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай зохицуулалт нь хамгийн чухал өөрчлөлт болсон.

Энэхүү хуульд тухайн үеийн Австри-Унгарын эзэнт улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (1895) чухал нөлөө үзүүлсэн. Уг хууль нь "хэрэгт хамаарах бодит үйл баримтыг нээн илрүүлэх (真実発見) ба хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай (迅速な訴訟)" хэрэгжүүлэх зорилготой бөгөөд "социал процессын хууль(社会的な訴訟手続法)" гэж нэрлэгддэг.²⁰ Тус хуулийн төслийг боловсруулсан Австри Улсын хууль зүйн ухааны эрдэмтэн, улс төрч Франц Клейн (Franz Klein)-ны үзэл баримтлалд хэрэг хянан шийдвэрлэх

¹⁴ 林屋礼二・前掲注 (13) 450頁~452頁。

¹⁵ 福田剛久「当事者主義と職権主義の間で」判例タイムズ 1317号 (2010年) 46頁。

¹⁶ 松村和「『手集集中論』(成文堂、2019年) 17頁。

¹⁷ 福田剛久「当事者主義と職権主義の間で」判例タイムズ 1317号 (2010) 69頁。

¹⁸ 249 дүгээр зүйл "Шүүхийн тогтоол гарснаар урьдчилсан хэлэлцүүлгийг явуулна. Гэхдээ шүүх шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг зарлан хуралдуулах, эсхүл нэхэмжлэлийн зарим хэсэг, эсхүл тухайн маргааны зүйлд холбогдуулан урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай тогтоол гаргаж болно".

¹⁹ 139 дүгээр зүйл "Хэргийн оролцогч нар санаатайгаар эсвэл хэт болгоомжгүй байдлаар хугацаа хоцорч гаргасан хүсэлт, тайлбар, нотлох баримтыг хүлээн авснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж удаашруулна гэж үзвэл, шүүх өөрийн санаачилгаар буюу нөгөө талын хүсэлтээр хэрэгсэхгүй болгоно. Талуудын гаргасан хүсэлт, тайлбарын утга санаа нь тодорхойгүй бөгөөд шүүхийн тодруулгад тайлбар гаргаагүй, эсхүл тодруулга хийхээр тогтоосон өдөрт ирээгүй тохиолдолд мөн адил хэрэгсэхгүй болгоно".

²⁰ 松村和徳「わが国におけるオーストリア民事訴訟法の受容」『日本法の中の外国法—基本法の比較的考察 (早稲田大学比較法研究所編 41)』(成文堂・2014年) 219~227頁。



ажиллагааны удаашралын улмаас шүүх хуралдаан хэлбэрийн төдий явагдах²¹, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал²², социализм болон социал төр (welfare state)-ийн тухай онол тус тус нөлөө үзүүлсэн.²³

Тэрээр иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь "хурдан шуурхай", "хэрэгт хамаарах бодит үйл баримтыг нээн илрүүлэх"-д чиглэсэн байх шаардлагатай гэж үзэж, үүнийг хэрэгжүүлэхийн тулд шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох шаардлагатай гэж үзсэн.²⁴ Түүнчлэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тасралтгүй явагдсанаар (verfahrenskonzentration) дээрх эсрэг тэсрэг 2 ойлголтыг үр дүнтэй хэрэгжүүлж чадна.²⁵ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулахын тулд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүтцийн өөрчлөлт (урьдчилсан хэлэлцүүлэг, дээд шатны шүүх зарим гомдлыг хүлээн авахаас татгалзах, зөвхөн анхан шатны шүүх нотлох баримтыг шинжлэн судлах гэх мэт) хийх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал болохыг онцолжээ.

Австри-Унгарын эзэнт улсын хууль нь 1925 оны Японы хуульд чухал нөлөө үзүүлсэн боловч тус улс нь өөрийн орны онцлогт тохирсон урьдчилсан хэлэлцүүлгийн тогтолцоог бий болгосон. 1929 оноос урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалт хэрэгжиж эхэлсэн бөгөөд эхний 3 жилийн хугацаанд үр дүнтэй явагдсан боловч аажмаар үр нөлөө нь буурч, улмаар урьдчилсан хэлэлцүүлэг явагдахаа больсон.²⁶

Үүний нэг шалтгаан нь урьдчилсан хэлэлцүүлгийн үед гаргаагүй тайлбар хүсэлт, нотлох баримтуудыг шүүх хуралдаанд гаргах боломжгүй байсантай холбоотой. Ийм нөхцөлд хэргийн оролцогч нар урьдчилсан хэлэлцүүлэгт шаардлагагүй олон тайлбар хүсэлт, нотлох баримт гаргаж маргааны зүйлийг өргөжүүлэх болсон.²⁷ Нөгөөтээгүүр аажимдаа энэ зохицуулалтыг хатуу дагаж мөрдөхөө больж, шүүх хуралдаанд шинэ тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах болсноор урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго алдагдсан.²⁸ Шүүх хэргийг шийдвэрлэхэд хангалттай хэмжээний нотлох баримт, тайлбар шаардлагатай учир хугацаа хоцорсон тайлбар хүсэлт, нотлох баримтыг хүлээн авахаас өөр аргагүй болсноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тасралтгүй явагдах зарчим алдагдаж, урьдчилсан хэлэлцүүлэг хэлбэрийн төдий зохицуулалт болж хувирсан. Түүнчлэн шүүх хуралдааныг нээлттэй, амаар, шууд биечлэн явуулах зарчмыг хангах үүднээс урьдчилсан хэлэлцүүлэг явуулах шүүгчийн бүрэн эрх бага байсан

²¹ Шүүгчийн бүрэн эрх нэлээд хязгаарлагдмал, хэргийн оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүрэн даатгуулсны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөл үүссэн гэж үзсэн.

²² 19 дугаар зууны сүүл үеэс арилжааны үйл ажиллагаа эрчимжиж, улмаар шүүхэд хандах хэрэг, маргааны тоо нэмэгдсэнээр хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх шаардлага бий болсон. Түүнчлэн ажилчин ангид хамаарах хөдөлмөр эрхлэгчдийн тоо нэмэгдсэнээр хэргийн оролцогчийн шинж байдал өөрчлөгдсөн.

²³ 松村和徳・前掲注(20) 216頁~217頁。

²⁴ 松村和徳・前掲注(20) 218頁。

²⁵ 松村和徳・前掲注(20)。

²⁶ 松村和徳・前掲注(20) 253頁。

²⁷ 斎藤秀夫ほか筆者代表『注釈民事訴訟法(4)』(第一法規出版株式会社・1975年) 278頁。

²⁸ 斎藤秀夫ほか筆者代表・前掲注(27)。



нь урьдчилсан хэлэлцүүлгийн үр нөлөөг сулруулсан.²⁹ Эцэст нь зөвхөн ээдрээ төвөгтэй хэрэг, маргаанд урьдчилсан хэлэлцүүлэг явагддаг болсон.³⁰

б. Дэлхийн хоёрдугаар дайны дараах үеийн зохицуулалт

Дэлхийн хоёрдугаар дайны дараа 1948, 1950, 1956 онуудад урьдчилсан хэлэлцүүлгийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан. 1947 онд баталсан Шүүхийн тухай хуулиар шүүгч дангаар хэргийг хянан шийдвэрлэх тогтолцоог нэвтрүүлсэн бөгөөд урьдчилсан хэлэлцүүлгийн хэрэгжилт хангалтгүйн улмаас 1948 оны нэмэлт, өөрчлөлтөөр шүүх шаардлагатай гэж үзсэн бол зөвхөн бүрэлдэхүүнтэй хэрэгт урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар болсон.³¹ 1949 оны 1 дүгээр сарын байдлаар нийт иргэний хэргийн дөнгөж 3 хувьд л урьдчилсан хэлэлцүүлэг явагдсан.³² Үүний дараа 1950 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр урьдчилсан хэлэлцүүлгийг хаалттай явуулахаас гадна, хэргийг хүлээн авснаас өөр шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийг удирдан явуулахаар болсон.³³

Гэвч шүүхийн ажлын ачааллаас шалтгаалж урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахгүй байх, урьдчилсан хэлэлцүүлгийг явуулах шүүгчийн бүрэн эрх хязгаарлагдмал, хэргийн оролцогчид урьдчилсан хэлэлцүүлэгт идэвхгүй байх, материаллаг болон хүний нөөцийн дутагдал зэргийн улмаас 1956 онд дахин нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүний хүрээнд хэрэг, маргааны төвөгтэй байдлыг харгалзан шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар болсон. Урьдчилсан хэлэлцүүлэг нь шүүх хуралдааны ээлбэрээр (準備的口頭弁論) явагдах болсон тул нэхэмжлэлийн шаардлагыг өөрчлөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан дундын шүүхийн шийдвэр (interlocutory decision, 中間判決), бичмэл нотлох баримтуудыг шинжлэн судлах боломжтой болсон.³⁴ Түүнчлэн шүүх хуралдаан дуусах хүртэлх хугацаанд хэргийн оролцогчид тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах боломжтой болсон.³⁵

1969 оны шүүхийн статистик мэдээнээс үзэхэд нийт хэргийн 1.5 хувьд л урьдчилсан хэлэлцүүлэг явагджээ.³⁶ 1970 оны анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа 12.8 сар, 1975 онд 16.3 сар, мөн хяналтын шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл дунджаар 6 орчим жил зарцуулагддаг байжээ.³⁷ Тухайн үед хэргийн оролцогчид өөрсдийн тайлбараа шүүх хуралдаанд дурдах бөгөөд маргааны зүйлийг тодорхой болгохгүйгээр нотлох баримт шинжлэн судлах хэсэг рүү шилждэг байсан ба нотлох баримт шинжлэн судлах үед шинээр маргааны зүйл үүсэх, хэрэгт хамаарах ач холбогдолтой нотлох баримтыг

²⁹ 三ヶ月章・前掲注(12)193頁。

³⁰ 沢栄三「民事における集中審理の経験」法曹時報23巻6号(1971年)4頁。

³¹ 福田剛久・前掲注(15)82頁。

³² 司法研修所編『準備手続の実務上の諸問題(第1版)』(法曹会・1989年)10頁。

1948 оны нэмэлт, өөрчлөлтөөр шүүх бүрэлдэхүүний даргалагч биш шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийг явуулж байсан ч шүүх хуралдааны үед даргалагч шүүгч хэргийн талаар тодруулах явдал их байсан.

³³ 司法研修所編・前掲注(33)11頁。

³⁴ 三ヶ月章『民事訴訟法(補正版)』(有斐閣・1981年)411頁。

³⁵ 137 дугаар зүйл "Хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн оролцогчид шүүх хуралдаан дуусах хүртэлх хугацаанд тайлбар хүсэлт, нотлох баримт гаргаж болно".

³⁶ 斎藤秀夫ほか筆者代表・前掲注(27)292頁。

³⁷ 門口正人ほか『裁判官の観点 民事裁判と専門訴訟』(商事法務・2018年)5頁。



дахин бүрдүүлэх шаардлага үүссэний улмаас шүүх хуралдаан хойшлогдохоос өөр аргагүй болдог байсан.³⁸ Ийнхүү тухайн үеийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг 5 сарын борооны улиралтай адилтган зүйрлэж байсан түүхтэй.

1980 оны дунд үеэс шүүх болон өмгөөлөгчдийн холбоо хамтран иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг шинэчлэх хөдөлгөөнийг эхлүүлж, шүүх хуралдаан эхлэхээс өмнө бэлтгэл хуралдаан (弁論兼和解) явуулах практик нэвтэрсэн. Энэ нь хуульд заасан урьдчилсан хэлэлцүүлгээс ялгаатай бөгөөд Германы Штутгарт хотын анхан шатны шүүхэд хэрэгжсэн арга туршлагаас санаа авсан практик шинэчлэл юм.³⁹

Бэлтгэл хуралдааныг явуулахын тулд эхлээд талуудын зөвшөөрлийг авах бөгөөд шүүх хуралдааны танхимд бус, эвлэрлийн өрөө эсвэл тусгайлан бэлтгэсэн өрөөнд зохион байгуулдаг байв. Энэ үеэр шүүгч болон талууд ширээ тойрон сууж маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтуудыг тодорхой болгосны дараа шүүх хуралдааны үеэр маргааны зүйлд төвлөрөн нотлох баримтыг шинэчлэн судалдаг болсон. Ийнхүү практик шинэчлэлийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа богиносхын зэрэгцээ хэргийн оролцогчид эвлэрэх тохиолдол нэмэгдсэн. Гэвч тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан процессын хуульд уг бэлтгэл хурал холбогдох зохицуулалт байхгүй тул бэлтгэл хуралдааны хүрээ хязгаар тодорхой бус байв. Түүнчлэн бэлтгэл хуралдаан хаалттай явагддаг байсан бөгөөд шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчимд харшилсан гэх шүүмжлэл дагуулж, мөн шүүгч бүрийн бэлтгэл хуралдаан удирдах арга барил харилцан адилгүй байв.⁴⁰

³⁸ 門口正人ほか・前掲注(37)6頁~7頁。

³⁹ Rolf Bender (シュトットガルド高裁判事)《木川統一郎と伊藤 瑩子》) 訳「訴訟促進: 日本の雑誌「ジュリスト」に寄せて」ジュリスト477号(1971年)125頁。

Шүүх хуралдаан эхлэхийн өмнө талууд урьдчилсан хэлэлцүүлэгт оролцож, шүүгч зохих хугацааны дотор заавар өгч шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг хангасан тохиолдолд нэг удаа шүүх хуралдаан явуулах зарчим хэрэгжих боломжтой болдог. Германы Штутгарт хотын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 20 дугаар хэлтэс 1967 оноос эхлэн дараах байдлаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж эхэлсэн. Шүүх талуудын тайлбар, хариу тайлбаруудыг гаргуулж, шаардлагатай зааврыг талуудад өгч, тохиромжтой хугацааны дотор шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг явуулсны дараа шүүх хуралдааны товыг зарладаг болсон. Үүний үр дүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа 1 жилээс илүүгүй болсон. Штутгарт хотын шүүхийн хэрэгжүүлсэн тус аргыг сайн туршлага болгон Германы процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан түүхтэй.

⁴⁰ 鈴木正裕「弁論兼和解方式について」民事訴訟雑誌36号(1990年)41頁。

ЯВЦЫН ДҮГНЭЛТ

1890 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд анх зарим төрлийн хэрэг, маргаанд шүүх хуралдааны бэлтгэл ажиллагаа явуулах тухай зохицуулж байсан боловч шүүхийн эрх хэмжээ хэт хязгаарлагдмал байсны улмаас сайн хэрэгжиж чадаагүй.

Тухайн үед зөвхөн Япон гэлтгүй дэлхийн ихэнх улс орнуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал тулгамдсан асуудал болж байсан. Үүнийг шийдвэрлэх зорилгоор Австрийн хууль зүйн ухааны эрдэмтэн, улс төрч Франц Клейн "Социал процесс хууль"-ийн үзэл баримтлалыг боловсруулсан бөгөөд энэ нь 1925 оны Японы Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нөлөө үзүүлж, анх удаа иргэний хэрэг, маргаанд урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаар болсон. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш эхний 3 жилийн хугацаанд урьдчилсан хэлэлцүүлэг үр дүнтэй явагдсан. Гэхдээ шүүх хуралдаанд шинэ тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах эрхийг хориглосны улмаас урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр хэрэгт хамааралтай, хамааралгүй бүхий л тайлбар, нотлох баримтыг гаргах болсноор гол маргааны зүйл, ач холбогдолтой нотлох баримтыг тодорхойлох үйл явц удааширсан.

Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар 3 удаа урьдчилсан хэлэлцүүлэгтэй холбоотойгоор хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч үр дүнтэй байж чадаагүй. Түүнчлэн анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа маш урт болсон. Үүний улмаас 1980 оны дунд үеэс шүүх болон өмгөөлөгч нар хамтран практик шинэчлэл хийсэн нь үр дүнтэй байсан хэдий ч эрх зүйн зохицуулалт байхгүй, шүүх хуралдааны нээлттэй явуулах зарчимд харшилсан, шүүгч бүрийн арга барил өөр зэрэг асуудлууд бий болсон.

2.2. 1996 оноос хойших урьдчилсан хэлэлцүүлэг

Энэхүү хэсэгт 1996 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан урьдчилсан хэлэлцүүлгийн тухай зохицуулалт, 2004, 2022 онд хийсэн нэмэлт, өөрчлөлт болон урьдчилсан хэлэлцүүлэгт тулгамдаж байгаа асуудал зэргийн тухай авч үзэх болно.

2.2.1. 1996 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль батлагдах үйл явц

1925 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг дараах хүчин зүйлүүдийн улмаас шинэчлэн найруулах шаардлагатай болсон.⁴¹ Нэгдүгээрт, нийгэм эдийн засгийн хурдацтай хөгжлийг даган иргэний хэргийн төвөгтэй байдал нэмэгдсэн. Хоёрдугаарт, өмнөх хэсэгт дурдсанчлан иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд зарцуулах хугацаа болон зардал өндөр байгаагийн улмаас шүүхээс үйлчилгээ авах иргэдийн сонирхол буурсан. Гуравдугаарт, практикт явуулсан шинэчлэлийг хуульд тусгах шаардлага бий болсон.

Ийнхүү 1990 оноос эхлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн найруулах тухай ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд иргэн

⁴¹ 柳田幸三「新民事訴訟法について」ジュリスト1098号（1996年）18頁。



төвтэй иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгох зорилготойгоор хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулахаар болсон.⁴² 1996 онд батлагдсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 1998 оноос эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн.

Уг шинэчилсэн найруулгын хүрээнд хийгдсэн гол өөрчлөлт нь маргааны зүйл болон нотлох баримтыг тодорхойлох зорилготой урьдчилсан хэлэлцүүлэг болон түүний төрөл, холбогдох зарим процесс ажиллагааг хуульчилсан явдал юм. Түүнчлэн нотлох баримтыг цуглуулах журмыг өргөжүүлсэн, бага үнийн дүнтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульчилж, хяналтын шатны журмаар хүлээж авах гомдлын үндэслэлийг хязгаарласан явдал юм. Мөн "маргааны зүйлд төвлөрсөн" хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бий болгосон нь томоохон ахиц дэвшил болсон.

2.2.2. Урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго болон холбогдох зарим процесс ажиллагаа

Урьдчилсан хэлэлцүүлгийн талаар дэлгэрэнгүй авч үзэхээс өмнө тус улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг товч авч үзье. Нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргаснаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлдэг. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авч нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангасан эсэхийг хянан шалгана (ИХШХШТХ-н 137-р зүйл ИХШХШТД-н 56-р зүйл). Үүний дараа эхний шүүх хуралдааны товыг зарлаж (ИХШХШТХ-н 139-р зүйл ИХШХШТД-н 60-р зүйл), хариуцагчид нэхэмжлэл болон шүүх хуралдааны товыг хүргүүлнэ (ИХШХШТХ-н 138-р зүйл).

Эхний шүүх хуралдааны үеэр хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эсэргүүцэж байгаа эсэхийг тодруулна.⁴³ Хэргийн оролцогч нарын хооронд маргааны зүйл байхгүй тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, эсхүл маргааны зүйл ойлгомжтой, шинжлэн судлах нотлох баримт цөөхөн тохиолдолд урьдчилсан хэлэлцүүлэг явуулахгүйгээр шүүх хуралдааныг үргэлжлүүлэх эсвэл дараагийн шүүх хуралдааны товыг тогтоодог. Харин маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтуудыг тодорхойлох шаардлагатай бол урьдчилсан хэлэлцүүлэг явуулдаг. Түүнчлэн тус улсад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хуулиар тогтоогүй боловч, анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хэргийг 2 жилийн дотор хянан шийдвэрлэж дуусгах тухай нарийвчилсан зохицуулалттай хуульд заасан байдаг.⁴⁴ Тэгэхдээ энэ нь заавал дагаж мөрдөх императив хэм хэмжээ биш.

Урьдчилсан хэлэлцүүлэг нь маргааны зүйлд төвлөрсөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол цөм нь болсон. Урьдчилсан хэлэлцүүлэг (Proceedings for Arranging Issues and Evidence, 争点整理手続)-ийн зорилго нь маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтуудыг тодорхойлж, эдгээрийн талаар хэргийн оролцогч болон шүүгч нар ижил ойлголттой болоход

⁴² 柳田幸三・前掲注(41)17頁。

⁴³ 司法研修所監修『4 訂民事訴訟第一審手続の解説【事件記録に基づいて】』（法曹会・2001年）22頁。

⁴⁴ 裁判の迅速化に関する法律（2004年）、<https://laws.e-gov.go.jp/law/415AC0000000107>



оршино.⁴⁵ Урьдчилсан хэлэлцүүлгийн дараа явагдах шүүх хуралдааны үеэр тодорхой болсон маргааны зүйлд төвлөрөн гэрчийн мэдүүлэг болон зохигчийн тайлбарыг шинжлэн судалдаг (ИХШХШ-н дүрэм 182-р зүйл). Шүүх хуралдаан нь 1 өдрийн дотор, эсхүл хэд хэдэн өдрийн дотор явагдаж дуусдаг. Ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хурдан шуурхай явагдахаас гадна хэрэгт хамаарах бодит үйл баримтыг тогтоох боломж бүрдэнэ.⁴⁶

Түүнчлэн урьдчилсан хэлэлцүүлгийн явцад үүссэн өөрийн дотоод итгэл үнэмшлээ шүүгч талуудад илэрхийлэх шаардлагатай. Үүнийг "Түр зуурын дотоод итгэл үнэмшил"⁴⁷ (temporary conviction, 暫定的心証) гэж нэрлэдэг. Үүнээс гадна шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулахын тулд шүүхийн тодруулах эрх хэмжээг идэвхтэй хэрэглэж, мөн хэлэлцүүлгийн явцад тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах хугацааг тогтоодог. Урьдчилсан хэлэлцүүлгийн явцад маргааны зүйл болон нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагааны уялдаа холбоог тодруулах зорилгоор дундын хурал⁴⁸ (進行協議期日)-ыг зохион байгуулж болдог (ИХШХШ-н дүрэм 95-р зүйл).

2004 онд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төлөвлөлт (計画審理) хэмээх ойлголтыг шинээр хуульчилсан. Зарчмын хувьд бүхий л иргэний хэрэгт шүүх болон хэргийн оролцогч нар хэргийг төлөвлөн явуулах шаардлагатай (ИХШХШТХ-н 147-2).

Тэгэхдээ зөвхөн ээдрээ төвөгтэй хэрэгт хэргийн оролцогч нар зөвшөөрсөн тохиолдолд маргааны зүйл болон нотлох баримтыг тодорхой болгох хугацаа (урьдчилсан хэлэлцүүлэг), гэрч болон талуудаас тайлбар авах хугацаа, шүүх хуралдаан дуусах болон шүүхийн шийдвэр танилцуулах хугацаа зэргийн талаар шүүх болон хэргийн оролцогч нар урьдчилан тохирно (ИХШХШТХ-н 147-3.1,2). Хэрвээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл хэргийн оролцогчтой зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөх боломжтой (ИХШХШТХ-н 147-3.4).

Шүүхийн практикт одоогийн байдлаар ээдрээ төвөгтэй хэрэгт төлөвлөгөө гаргасан тохиолдол байхгүй байна. Учир нь хэргийн оролцогч нарын хувьд төлөвлөгөөний дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох нь хүндрэлтэй байдаг.⁴⁹

⁴⁵ シンポジウム「民事裁判手続に関する運用改善提言」判例タイムズ 1492号(2021年)14頁に詳しく書かれている。Bүрэлдэхүүнтэй явагдах хэрэгт бүрэлдэхүүний нэг шүүгч нь урьдчилсан хэлэлцүүлгийг удирдан явуулна。

⁴⁶ 三木浩一ほか『民事訴訟法(第4版)』(有斐閣・2023年)186~187頁。

⁴⁷ Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсгээс үзнэ үү。

Н.Норовсамбуу, Б.Хонгорзул, "Улсын дээд шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэлд хийсэн дүн шинжилгээ", 2020, 66 дахь тал。

⁴⁸ Мөн тэндээс үзнэ үү, 61 дэх тал。

⁴⁹ 2023年6月20日に、竹内幸伸裁判官、上松健太郎弁護士(いずれも名古屋大学大学院法学研究科実務法曹養成専攻実務家教員 准教授)に対して行った争点整理手続の実務に関するヒアリングによる。



2.2.3. Урьдчилсан хэлэлцүүлгийн төрөл

Урьдчилсан хэлэлцүүлэг нь хуульд зааснаар нээлттэй урьдчилсан хэлэлцүүлэг (preliminary oral arguments, 準備的口頭弁論), хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг (preparatory proceedings, 弁論準備手続), бичгээр явагдах урьдчилсан хэлэлцүүлэг (written preparatory proceedings, 書面による準備手続) гэсэн 3 төрөлтэй. Эдгээрийн тухай доорх хэсэгт дэлгэрэнгүй авч үзье.

a. Нээлттэй урьдчилсан хэлэлцүүлэг

Шүүх маргааны зүйл болон нотлох баримтыг тодорхойлох шаардлагатай гэж үзвэл нээлттэй урьдчилсан хэлэлцүүлгийг явуулж болно (ИХШХШТХ-н 164-р зүйл). Хэлэлцүүлэг нь шүүх хуралдаантай адил нээлттэй явагдах тул уг хэлэлцүүлгийг явуулах эсэх талаар талуудын саналыг шүүх сонсох шаардлагагүй.⁵⁰ Тус хэлэлцүүлэг нь нээлттэй хэлбэрээр явагддагаараа нөгөө 2 урьдчилсан хэлэлцүүлгээс ялгаатай. Олон нийтийн анхаарлыг татсан, олон хэргийн оролцогчтой хэрэгт явагддаг.⁵¹ Бусад 2 урьдчилсан хэлэлцүүлгээс ялгаатай нь нээлттэй явагддаг учраас бүхий л нотлох баримтыг шинжлэн судлах, шүүх хуралдааны үеэр хэрэгжүүлж болох бүхий л процесс үйлдлийг хийх боломжтой.⁵²

Хэлэлцүүлэг болох өдөр хэргийн оролцогчид ирээгүй, шүүхээс тогтоосон хугацаанд тайлбар болон нотлох баримтаа гаргаж өгөөгүй тохиолдолд шүүх хэлэлцүүлгийг дуусгавар болгож болно (ИХШХШТХ-н 166-р зүйл). Тус зохицуулалт нь хэргийн оролцогчийн идэвх санаачилгагүй байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрахаас сэргийлэх зорилготой.⁵³ Хэлэлцүүлэг дуусах үед шүүх болон хэргийн оролцогч нар маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтыг баталгаажуулдаг (ИХШХШТХ-н 165-р зүйл 1 дэх хэсэг).

b. Хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг

Хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг нь өмнөх хуулийн үед практикт хийгдсэн бэлтгэл хуралдааны хуульчлагдсан хэлбэр. Шүүх шаардлагатай гэж үзэж, талууд зөвшөөрсөн тохиолдолд хаалттай урьдчилсан хэлэлцүүлгийг явуулна (ИХШХШТХ-н 168-р зүйл). Шүүхийн практикт дийлэнхдээ хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг явагддаг. Эхний шүүх хуралд хаалттай урьдчилсан хэлэлцүүлгийг явуулах эсэхийг шийдэх нь түгээмэл боловч хэргийн оролцогчид эсэргүүцээгүй тохиолдолд эхний шүүх хуралдаан зарлахаас өмнө нь хаалттай урьдчилсан хэлэлцүүлгийг явуулж болно (ИХШХШТХ-н дүрэм 60-р зүйл). Хэлэлцүүлгийн өрөө нь шүүх хуралдааны танхимд бус дугуй ширээнд явагддаг бөгөөд шүүгч шүүгчийн өмсгөлгүй оролцож, талуудтай чөлөөтэй ярилцах орчин бүрдсэн онцлогтой.⁵⁴ Хэлэлцүүлэг хаалттай явагдах боловч талууд хүсэлт гаргасан, эсхүл шүүх шаардлагатай гэж үзвэл ажиллагчаар зарим этгээдийг оролцуулж болно (ИХШХШТХ-н 169-р зүйл 2 дахь хэсэг). Түүнчлэн, зохигч итгэмжлэгдсэн төлөөлөгчгүй буюу өмгөөлөгчгүй⁵⁵

⁵⁰ 三木浩一ほか・前掲注(46)188頁。

⁵¹ 安西明子ほか『民事訴訟法(第3版)』(有斐閣、2023年)121頁。

⁵² 三木浩一ほか・前掲注(46)。

⁵³ 三木浩一ほか・前掲注(46)189頁。

⁵⁴ 三木浩一ほか・前掲注(46)。

⁵⁵ Тус улсад хуульчийн эрхгүй этгээд бусдыг шүүхэд сайн дурын үндсэн дээр төлөөлөх эрхгүй байдаг.



оролцож байгаа тохиолдолд практикт хаалттай урьдчилсан хэлэлцүүлгийг шүүх хуралдааны танхимд явуулдаг. Өмгөөлөгчгүй оролцож байгаа зохигч нь эрх зүйн мэдлэггүй байх нь түгээмэл байхаас гадна, танхимд байгаа бусад хүмүүс рүү орилох, уурлах гэх мэт сэтгэл зүйн хөдлөл үзүүлэх эрсдэлтэй учраас аюулгүйн байдлын үүднээс шүүх хуралдааны танхимд явагддаг.⁵⁶

2022 оны нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө хэргийн оролцогчийн аль нэг нь шүүхээс хол оршин суудаг бол утсаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулдаг байсан. Энэ тохиолдолд зохиогчийн аль нэг нь заавал хэлэлцүүлгийн өрөөнд байх шаардлагатай. 2022 оны нэмэлт, өөрчлөлтөөр хэргийн оролцогч нарын аль нэг нь хол газар оршин суух, энэ тохиолдолд хэлэлцүүлгийн өрөөнд заавал байх зэрэг нөхцөлийг хүчингүй болгож, улмаар талууд зөвшөөрсөн тохиолдолд хэлэлцүүлэг нь цахимаар эсвэл утсаар явагдах боломжтой болсон (ИХШХШТХ-н 170-р зүйл 3 дахь хэсэг).

Хэлэлцүүлгийн үеэр хэргийн оролцогчид тайлбар болон нотлох баримт гаргаж, нотлох баримт гаргуулах тухай хүсэлт гаргах, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, нэхэмжлэлээс татгалзах, талууд хоорондоо эвлэрэх, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох боломжтой.⁵⁷ Түүнчлэн бичмэл нотлох баримт шинжлэн судлах ажиллагаа явуулж болдог (ИХШХШТХ-н 167-р зүйл). Бичмэл нотлох баримт шинжлэн судлах нь тухайн баримтыг уншихаас хэтрэхгүй тул зөвхөн шүүх хуралдааны үеэр судлах шаардлагагүй.⁵⁸ 2022 оны нэмэлт, өөрчлөлтөөр шинжээчийн дүгнэлт, аливаа байгууллагаас хэрэгт холбогдох асуудлаар гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлгийн явцад шинжлэн судлах боломжтой болсон (ИХШХШТХ-н 170-р зүйл 2 дахь хэсэг).

Маргааны зүйл, ач холбогдолтой нотлох баримтыг тодорхой болгосон буюу үр дүнтэй явагдсан тохиолдолд хэлэлцүүлэг дуусгавар болно. Эсвэл үр дүнд хүрэх боломжгүй болох нь илт байвал мөн адил дуусгавар болно. Хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг дуусгавар болсны дараа дахин явуулах боломжтой (ИХШХШТХ-н 170.5, 153-р зүйл). Хэлэлцүүлэг дуусах үед шүүх болон хэргийн оролцогч нар маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтыг баталгаажуулдаг (ИХШХШТХ-н 170-р зүйл 5 дэх хэсэг). Шүүх хуралдааныг амаар, нээлттэй явуулах зарчмын шаардлагыг хангах үүднээс хэлэлцүүлгийн явцад тодорхой болсон маргааны зүйл болон нотлох баримтыг шүүх хуралдааны эхэнд танилцуулдаг.

в. Бичгээр явуулах урьдчилсан хэлэлцүүлэг

Энэхүү хэлэлцүүлгийн онцлог нь хэргийн оролцогчид шүүхэд хүрэлцэн ирэлгүйгээр бичгээр тайлбар, нотлох баримтаа гаргаж, шаардлагатай бол шүүхээс утсаар эсвэл цахимаар холбогдон хэргийг тодруулах замаар маргааны зүйл болон нотлох баримтыг тодорхой болгоход оршино.⁵⁹ Бусад урьдчилсан хэлэлцүүлгээс ялгаатай нь нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаа явагдахгүй.

Шүүх шаардлагатай гэж үзэж, талууд зөвшөөрсөн бол бичгээр явуулах

⁵⁶ 竹内幸伸裁判官、上松健太郎弁護士へのヒアリングによる・前掲注(49)。

⁵⁷ 三木浩一ほか・前掲注(46)190頁。

⁵⁸ 三木浩一ほか・前掲注(46)。

⁵⁹ 伊藤真『民事訴訟法への招待』(有斐閣・2022年)117頁。



урьдчилсан хэлэлцүүлгийг явуулна (ИХШХШТХ-н 175-р зүйл). 2022 оны нэмэлт, өөрчлөлтөөс өмнө "хэргийн оролцогчид шүүхээс хол газар оршин суудаг" гэх нөхцөлд бичгээр явуулах урьдчилсан хэлэлцүүлгийг явуулдаг байсан. Түүнчлэн шүүх хуралдаан даргалагч буюу туршлагатай шүүгч уг хэлэлцүүлгийг удирддаг байсан бол 2022 оны нэмэлт, өөрчлөлтөөр тус шаардлагыг хэрэгсэхгүй болгосон.

Учир нь Ковид-19 цар тахлын үед урьдчилсан хэлэлцүүлгийг цахимаар явуулах хууль зүйн боломж нь бичгээр явуулах урьдчилсан хэлэлцүүлэг байсан бөгөөд цахимаар явуулах хэлэлцүүлэг нь бодитой уулзаад явуулах хэлэлцүүлэгтэй төдийлөн ялгаагүй байсан тул хэргийн оролцогчид хол газар оршин суудаг, туршлагатай шүүгч удирдах зэрэг нөхцөлүүд ач холбогдолгүй болсон.⁶⁰

Хэлэлцүүлгийн явцад тодорхойлсон маргааны зүйл болон нотлох баримтыг баталгаажуулах ажлыг хэлэлцүүлэг дуусгавар болсны дараах шүүх хуралдааны үеэр хэрэгжүүлдэг (ИХШХШТХ-н 177-р зүйл).

2.2.4. Урьдчилсан хэлэлцүүлэг дуусгавар болсны дараах хугацаа хоцорсон процесс үйлдэл

Урьдчилсан хэлэлцүүлэг дуусгавар болсны дараа хэргийн оролцогчийн аль нэг нь тайлбар хүсэлт, нотлох баримт шинээр гаргасан бол нөгөө тал нь шүүхэд хүсэлт гаргавал урьдчилсан хэлэлцүүлэг дуусахаас өмнө ямар шалтгааны улмаас гаргаж чадаагүй болохоо тайлбарлах үүрэгтэй (ИХШХШТХ-н 167-р зүйл, 174-р зүйл, 178-р зүйл). Энэ нь иргэний процессын эрх зүй дэх итгэлцлийг хамгаалах зарчимтай холбоотой.⁶¹ Түүнчлэн хугацаа хоцорсон процесс үйлдэл хийсэн этгээдэд өгч буй шийтгэл бус урьдчилсан хэлэлцүүлгийн үр дүнг хүндэтгэх сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлж буй хэлбэр.⁶²

Урьдчилсан хэлэлцүүлгээр тодорхой болсон маргааны зүйл, түүнд холбогдох ач холбогдолтой нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд 1996 оны шинэчилсэн найруулгаар тохиромжтой хугацаанд тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах зарчим (適時提出主義)-ыг хуульчилсан.⁶³

Тохиромжтой хугацаа гэдгийг хэргийн нөхцөл байдалд тулгуурлан объектив байдлаар тогтоодог.⁶⁴ Жишээ нь шүүхээс тогтоосон хугацааны дотор тайлбар хүсэлт, нотлох баримт гаргасан эсэх (ИХШХШТХ-н 162-р зүйл), урьдчилсан хэлэлцүүлэг явагдаж дууссан өдөр, шүүхэд гаргасан тайлбарыг өөрчлөх шаардлагатай тохиолдолд тухайн тайлбарыг өөрчлөхөд шаардагдах ердийн боломжит хугацаа өнгөрсөн зэрэг нь тохиромжтой хугацааг тогтооход шалгуур болдог.⁶⁵

Урьдчилсан хэлэлцүүлгийн дараа ирүүлсэн буюу хугацаа хоцроосон тайлбарыг

⁶⁰ 山本和彦『民事裁判手続のIT化』（弘文堂・2023年）60頁。

⁶¹ 新堂幸司『新民事訴訟法（第6版）』（弘文堂・2019年）543頁。Итгэлцлийг хамгаалах зарчмын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлд "Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шударга бөгөөд хурдан шуурхай явуулж, зохигчид сайн санааны үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ёстой" гэж заасан.

⁶² 三木浩一ほか・前掲注（46）194頁。

⁶³ 156.1 дугаар зүйл "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тохирсон тохиромжтой хугацааны дотор шүүхэд тайлбар хүсэлт, нотлох баримтаа гаргах ёстой"

⁶⁴ 法務省民事局参事官室『一問一答新民事訴訟法』（商事法務研究会、1996年）157頁。

⁶⁵ 三木浩一ほか・前掲注（46）149頁。



хүлээн авах эсэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 157 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Зохигчид санаатай, эсхүл хэт болгоомжгүйгээр хугацаа хоцроосон тайлбар хүсэлт, нотлох баримтыг гаргасны улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах бол шүүх өөрийн санаачилгаар эсвэл зохигчийн аль нэг талын хүсэлтээр хугацаа хоцорсон тайлбар, нотлох баримтыг хүлээн авахаас татгалзана" гэж заасан байдаг. Хэргийн оролцогч нар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах төлөвлөгөөнд заасан хугацааг хэтрүүлэн шүүхэд тайлбар хүсэлт, нотлох баримт гаргаж өгсний улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учрахаар бол шүүх өөрийн санаачилгаар, эсхүл талуудын хүсэлтээр тэдгээрийг хүлээн авахаас татгалзана (ИХШХШТХ-н 157-2).

Тус зүйлийн 157.1 дэх хэсэгт 1) хугацаа хоцроосон, 2) хугацаа хоцроосон үйлдэлд санаатай эсвэл хэт болгоомжгүй, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах зэрэг урьдчилсан нөхцөлүүдийг тусгажээ. Нэгдүгээрт, хугацаа хоцроосон гэдэг нь тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах хангалттай хугацаа байхад гаргаагүйг ойлгоно. Жишээ нь урьдчилсан хэлэлцүүлгийн дараа гаргасан тайлбар хүсэлт, нотлох баримт нь хугацаа хоцорсонд тооцогдоно.⁶⁶ Хоёрдугаарт, хугацаа хоцроосон үйлдэлд санаатай эсвэл хэт болгоомжгүй гэдгийг тогтооход ямар төрлийн тайлбар хүсэлт, нотлох баримт гаргасныг харгалзан үзэх нь ач холбогдолтой байхаас гадна, тухайн этгээдийн эрх зүйн боловсролыг мөн харгалзан үздэг.⁶⁷ Жишээ нь урьдчилсан хэлэлцүүлгийн дараа гаргасан тохиолдолд өмнө дурдсанчлан хугацаа хоцроосон этгээд нь тайлбар гаргах үүрэгтэй бөгөөд эл тайлбар үндэслэлтэй эсэхээс хамааран гэм буруутай эсэхийг тогтооно. Гуравдугаарт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах нөхцөл байгаа эсэхийг тогтоохын тулд хожимдсон тайлбар хүсэлт, нотлох баримтыг хүлээн авч шалгаснаар учирч болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа болон хүлээн авалгүй буцааснаар учирч болох хэрэг хянан шийдвэрлэх хугацаатай харьцуулан үздэг.⁶⁸ Жишээ нь шинээр гаргасан тайлбар хүсэлт, нотлох баримтыг тухайн мөчид шууд шинжлэн судлах боломжтой бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулсан гэж үзэхгүй.⁶⁹

Дээрхээс гадна хэргийн оролцогч нарын гаргасан тайлбар хүсэлт, нотлох баримт тодорхойгүй ба үүнтэй холбоотойгоор хэргийн оролцогчид шаардлагатай тайлбар хийгээгүй, эсхүл шүүхээс тодруулах ажиллагаа явуулах өдөр хэргийн оролцогчид хүрэлцэн ирээгүй тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 157.1-т заасантай адил эрх зүйн үр дагавар үүснэ (ИХШХШТХ-н 157-р зүйл 2 дахь хэсэг).

2.2.5. Урьдчилсан хэлэлцүүлэгт тулгамдаж буй асуудал ба шийдэл

1996 оны хуульд заасан урьдчилсан хэлэлцүүлэг хэрэгжиж эхэлснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа хэрхэн өөрчлөгдсөн эсэх, тулгамдаж байгаа зарим асуудлын талаар авч үзье.

2000 оноос хойш иргэний хэргийн анхан шатны журмаар хэрэг хянан

⁶⁶ 三木浩一ほか・前掲注(46)195頁。

⁶⁷ 新堂幸司・前掲注(61)528頁。


⁶⁸ 三木浩一ほか・前掲注(46)195頁。

⁶⁹ 三木浩一ほか・前掲注(46)。



шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацааны өөрчлөлтийг доорх графикт үзүүлэв.

График 1. 2000 оноос 2024 он хүртэлх хугацааны дундаж хугацаа⁷⁰



Дээрхээс үзвэл 2010 он хүртэлх хугацаанд анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа жил бүр буурч байсан ба 2008–2009 оны хооронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа хамгийн багадаа 6.5 сар байсан. Харин 2011 оноос эхлэн хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа ихсэж, тэр дундаа 2021–2022 оны хооронд хамгийн өндөр буюу 10.5 сар байжээ. 2023 оноос эхлэн буурч эхэлсэн үзүүлэлттэй байна.

2024 оны байдлаар тус улс анхан шатны журмаар нийт 139,370 хэргийг шийдвэрлэсэн⁷¹ бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа учир уг хугацааг доорх хүснэгтэд илүү нарийвчлан үзүүлэв.

Хүснэгт 1. Дундаж хугацааны нарийвчилсан задаргаа

Хугацаа	Эзлэх хувь
6 сарын дотор хянан шийдвэрлэсэн	80,923 буюу нийт хэргийн 58.1%
6–12 сарын дотор хянан шийдвэрлэсэн	24,870 буюу нийт хэргийн 17.8%
12–24 сарын дотор хянан шийдвэрлэсэн	22,960 буюу нийт хэргийн 16.5%
24–36 сарын дотор хянан шийдвэрлэсэн	7,098 буюу нийт хэргийн 5.1%
36–48 сарын дотор хянан шийдвэрлэсэн	3,048 буюу нийт хэргийн 2.2%
48 сараас дээш хугацаанд хянан шийдвэрлэсэн	480 буюу нийт хэргийн 0.3%

Дээрхээс үзвэл нийт хэргийн 58 хувийг 6 сарын дотор хянан шийдвэрлэсэн

⁷⁰ 最高裁判所「裁判の迅速化に係る検証に関する報告書（第3回）」27頁、2009年<https://www.courts.go.jp/vc-files/courts/file2/20507002.pdf>、2026年2月5日最終閲覧）。

最高裁判所「裁判の迅速化に係る検証に関する報告書（第11回）」47頁、2025年https://www.courts.go.jp/vc-files/courts/2025/11_houkoku_3_minji.pdf、2026年2月5日最終閲覧）。

⁷¹ 最高裁判所・前掲注（71）49頁。

бол, 17.8 хувийг 12 сарын дотор, 2 жилийн дотор 16.5 хувийг тус тус хянан шийдвэрлэсэн байна. Хоёроос дээш жилийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэрэг 7.8 хувьтай байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль хэрэгжиж эхэлснээс хойш 10 гаруй жилийн хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа багассан нь урьдчилсан хэлэлцүүлэг үр дүнтэй хэрэгжсэнтэй холбоотой юм. Гэхдээ 2011 оноос эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа тасралтгүй нэмэгдсэн бөгөөд үүний гол шалтгаан нь урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хугацаа нэмэгдсэнтэй холбоотой гэж тус улсын хуульч, судлаач нар үзэж байна.⁷² Тэгвэл урьдчилсан хэлэлцүүлэг явуулах дундаж хугацааг доорх хэсэгт авч үзье.

Хүснэгт 2. Урьдчилсан хэлэлцүүлгийн дундаж давтамж ба түүний дундаж хугацаа⁷³

	Урьдчилсан хэлэлцүүлгийн давтамж	Дундаж хугацаа
2008	2.3	1.6 сар
2016	3.0	1.8 сар
2022	2.6	2.6 сар
2024	2.5	2.5 сар

Дээрх хүснэгтээс үзэхэд 2008 оноос 2024 он хүртэлх хугацаанд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах давтамжийн тоонд төдийлөн өөрчлөлт байхгүй боловч түүний дундаж хугацаа 1 сараар нэмэгдсэн байна. Түүнчлэн шүүх хуралдаанд гэрчийн мэдүүлгийг шинжлэн судалсан хэргийн хувьд урьдчилсан хэлэлцүүлгийн дундаж давтамж 2008 онд 5.6 удаа, 2016 онд 7.3 удаа, 2022 онд 7.1 удаа, 2024 онд 7.3 удаа⁷⁴ явагджээ. Урьдчилсан хэлэлцүүлэг дараах шалтгааны улмаас сунжрах болсон. Үүнд:⁷⁵

- Зохистой хугацааны дотор хаалттай урьдчилсан хэлэлцүүлэгт шилжихгүй байх;
- Хэргийн оролцогчид тайлбар хүсэлт, нотлох баримтаа шуурхай гаргахгүй байх;
- Урьдчилсан хэлэлцүүлэгт оролцогч нар идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлэхгүй байх ба хоорондоо бичиг солилцох төдий явагдах.

Түүнчлэн, шүүгч маргааны зүйл, нотлох баримтыг тодорхойлох үйл явцыг чанартай сайн гүйцэтгэхийн тулд олон дахин урьдчилсан хэлэлцүүлгийг товлдог тохиолдол практикт байдаг.⁷⁶ Үүнээс гадна хэрэг, маргааны төвөгтэй байдал

⁷² 垣内秀介「民事訴訟の審理をめぐる問題状況」論究ジュリスト 24 号（2018年）7 頁。

⁷³ 「裁判の迅速化に係る検証に関する報告書（第3回）」10頁、2009年<https://www.courts.go.jp/vc-files/courts/file2/20507001.pdf> 2026年2月6日最終閲覧）。

「裁判の迅速化に係る検証に関する報告書（第11回）」54頁、2025年https://www.courts.go.jp/vc-files/courts/2025/11_houkoku_3_minji.pdf 2026年2月6日最終閲覧）。

⁷⁴ 最高裁判所・前掲注（71）57頁。

⁷⁵ シンポジウム・前掲注（45）41頁。

⁷⁶ 竹内幸伸裁判官、上松健太郎弁護士へのヒアリングによる・前掲注（49）。



нэмэгдэж байгаа нь урьдчилсан хэлэлцүүлгийг сунжруулах шалтгаан болж байгаа талаар онцолжээ.⁷⁷

2023 оноос эхлэн урьдчилсан хэлэлцүүлэг цахимаар явагдах хууль зүйн боломж нээгдсэн бөгөөд нийт шүүхээс урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулахын тулд дараах практик шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Юуны түрүүнд нэхэмжлэлийн зүйлийг тодорхой болгох, хэргийн гол үйл баримтад холбогдох маргааны зүйл болон нотлох баримтын талаар хэлэлцэж, эдгээрийн талаар хоорондоо ижил ойлголттой болох замаар цаашид урьдчилсан хэлэлцүүлгийг хэрхэн явуулах зураглал бий болгоно.⁷⁸ Тодруулбал, талуудын хүлээн зөвшөөрөөгүй бүхэн маргааны зүйл болох боломжтой боловч бүгд гол маргааны зүйл болж чадахгүй. Иймээс гол үйл баримтад тулгуурлан маргааны зүйлийг тодорхойлох шаардлагатай. Урьдчилсан хэлэлцүүлгийг хэргийн оролцогч нарт даалгаснаар ач холбогдолгүй маргааны зүйл нэмэгдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжрах эрсдэлтэй учир шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй удирдах хэрэгтэй болохыг онцолсон.⁷⁹

Мөн шүүхээс хэргийн оролцогчид урьдчилсан хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг сануулж, цахимаар оролцох бол цахим хэрэглэгдэхүүн ашиглах, хэлэлцүүлгийг 1 цагийн хугацаанд явуулах шаардлагатай.⁸⁰ Шүүгч урьдчилсан хэлэлцүүлгийн явцад өөрийн түр зуурын дотоод итгэл үнэмшлийг хэргийн оролцогчид илэрхийлсэн тохиолдолд түр зуурын дотоод үнэмшлээс татгалзах, татгалзсан бол шүүх хуралдаанд хэргийн оролцогчийн аль нэг нь үндэслэл болгохгүй.⁸¹

ЯВЦЫН ДҮГНЭЛТ

Олон жилийн хугацааны турш үргэлжилсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашралыг шийдвэрлэх гарц нь урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах явуулах юм. Тодруулбал маргааны зүйл, ач холбогдолтой нотлох баримтыг тодорхойлж, холбогдох нотлох баримтыг шинжлэн судалсны дараа шүүх хуралдаан нь маргааны зүйлд төвлөрөн гэрчийн мэдүүлэг, хэргийн оролцогчийн тайлбарыг шинжлэн судлах явдал юм.

Бүх хэрэг, маргаанд урьдчилсан хэлэлцүүлэг явагдахгүй бөгөөд маргааны зүйл, ач холбогдолтой нотлох баримтуудыг тодорхойлох шаардлагатай тохиолдолд ихэвчлэн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулдаг. Урьдчилсан хэлэлцүүлэг нь нээлттэй, хаалттай, бичгээр гэсэн 3 төрөлтэй. Шүүхийн практикт ихэвчлэн хаалттай урьдчилсан хэлэлцүүлэг явагддаг.

Урьдчилсан хэлэлцүүлэг дуусгавар болсны дараа шинээр тайлбар хүсэлт, нотлох баримт гаргасан тохиолдолд 1) хугацаа хоцроосон, 2) хугацаа хоцроосон

⁷⁷ 鼎談「裁判迅速化検証の20年とデジタル世代につなぐ理念—民事訴訟を中心に—」判例タイムズ 1512号（2024年）20頁（山本和彦発言）。

⁷⁸ 最高裁判所・前掲注（71）107頁。

⁷⁹ 竹内幸伸裁判官、上松健太郎弁護士へのヒアリングによる・前掲注（49）。

⁸⁰ 最高裁判所事務局「裁判の迅速化に係る検証結果の公表（第10回）について」判例タイムズ 1512号（2023年）19頁。

⁸¹ シンポジウム・前掲注（45）84頁。



үйлдэлд санаатай эсвэл хэт болгоомжгүй, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах боломжтой зэрэг хуульд заасан урьдчилсан нөхцөлүүд хангагдсан бол шүүх хүлээн авахаас татгалзана.

2022 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд урьдчилсан хэлэлцүүлгийг цахимаар явуулах хууль зүйн боломжтой болсон. Урьдчилсан хэлэлцүүлэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах явдлыг бууруулсан боловч, нөгөөтээгүүр урьдчилсан хэлэлцүүлэг явагдах давтамж, хугацаа нэмэгдсэнээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах болсон. Урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах зорилгоор практик шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд 2023 оноос эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа мэдэгдэхүйц буурсан байна.

III. ЯПОН УЛСЫГ САЙН ТУРШЛАГА БОЛГОХ НЬ

Энэхүү хэсэгт Япон Улсын урьдчилсан хэлэлцүүлгийн алдаа дутагдал, ололт амжилтыг харгалзан манай улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлэг нэвтрүүлэхэд цаашид анхаарах зарим асуудлыг дэвшүүлнэ.

Нэгдүгээрт, урьдчилсан хэлэлцүүлгийн зорилго нь маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтуудыг тодорхойлж, үүний дараа явагдах шүүх хуралдаан нь маргааны зүйлд төвлөрөн гэрчийн мэдүүлэг болон зохигчийн тайлбарыг шинжлэн судлахад оршино. Япон Улсад эхний шүүх хуралдаан нь хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор товлогдож, уг хуралдааны үеэр тухайн хэрэг, маргаанд урьдчилсан хэлэлцүүлэг явуулах эсэхийг шийдвэрлэдэг. Харин манай улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн наймдугаар бүлгээс үзэхэд шүүх хуралдааны бэлтгэл бүрэн хангагдсаны дараа шүүх хуралдааны товыг зарлах нэг үндэслэл болдог.

Дээрхийг харгалзан манай улсад дараах байдлаар урьдчилсан хэлэлцүүлэг болон шүүх хуралдааны уялдаа холбоог хангах боломжтой. Шүүх хуралдааны товыг зарлахаас өмнө эхний урьдчилсан хэлэлцүүлгийн товыг зарлаж, тус хэлэлцүүлгээр Япон Улсын эхний шүүх хуралдаантай адил талууд маргаж буй эсэх, цаашид дахин урьдчилсан хэлэлцүүлгийн өдөр товлож маргааны зүйл болон ач холбогдолтой нотлох баримтыг тодорхойлох шаардлагатай эсэхийг тогтоох, эсхүл шаардлагагүй гэж үзвэл шүүх хуралдааны товыг зарлах боломжтой. Гэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасан хугацаа урьдчилсан хэлэлцүүлгийн үр нөлөөг бууруулах эрсдэлтэй байна. Хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа нь хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх зорилготой боловч, нөгөөтээгүүр зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш 30 гаруй жилийн хугацаа өнгөрсөн одоо үед иргэний хэргийн ээдрээ төвөгтэй байдал нэмэгдсэн билээ. Тиймээс хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг өөрчлөх, эсхүл ийм хугацааг хуулиар тогтоохгүйгээр тухайн хэргийн нөхцөл байдалд тулгуурлан хамгийн боломжит богино хугацааны дотор хянан шийдвэрлэдэг болох боломжтой.



Япон Улсын урьдчилсан хэлэлцүүлэг нь 3 төрөлтэй боловч шүүх хуралдаан болон урьдчилсан хэлэлцүүлэг цахимаар явагдах боломжтой болсноор хаалттай болон бичгээр явагдах урьдчилсан хэлэлцүүлгийн ялгаа алга болсон. Манай улсын хувьд нээлттэй болон хаалттай хэлбэрээр урьдчилсан хэлэлцүүлэг явуулах тухай хуульд заах боломжтой.

Хоёрдугаарт, урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулахын тулд шүүхийн тодруулах эрх, шүүгчийн түр зуурын дотоод итгэл үнэмшлийг ил болгох, урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр зарим нотлох баримтуудыг шинжлэн судлах шаардлагатай. Манай улсын процессын эрх зүйд шүүхийн тодруулах эрх нь шинэ зүйл биш боловч түүний хэмжээ хязгаарыг хэрхэн зохицуулах эсэх тодорхойгүйгээс гадна түр зуурын дотоод үнэмшлийг ил болгох тухай асуудал төдийлөн судлагдаагүй байна. Түүнчлэн Япон Улсад 1996 оноос өмнө урьдчилсан хэлэлцүүлгийн үед зарим нотлох баримтыг шинжлэн судлах боломжгүй байсан нь урьдчилсан хэлэлцүүлгийг үр дүнгүй болгох нэг шалтгаан болж байсан түүхтэй. Иймд өөрийн орны онцлогт тулгуурлан зарим нотлох баримтуудыг урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр шинжлэн судлах боломжтой. Мөн урьдчилсан хэлэлцүүлгийн цахим хэлбэрээр явуулж болох бөгөөд ингэсэн тохиолдолд цахим хэрэглэгдэхүүнийг ашиглах нь хэлэлцүүлгийн үр дүнг нэмэгдүүлнэ.

Гуравдугаарт, Япон Улсад 1925 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар урьдчилсан хэлэлцүүлэг дуусгавар болсны дараа шинээр тайлбар хүсэлт, нотлох баримт гаргах боломжгүй байсны улмаас урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр ач холбогдолгүй тайлбар, нотлох баримт гаргах нь ихсэж урьдчилсан хэлэлцүүлэг явуулахад хүндрэл бий болгож байсан. Тиймээс урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр зөвхөн тайлбар хүсэлт, нотлох баримт гаргана гэж хуульд зохицуулбал ийм эрсдэл бий болох эрсдэлтэй. Түүнчлэн манай улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "хүндэтгэн үзэх шалтгаан"-ыг Япон Улсын одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 157 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 1) хугацаа хоцроосон, 2) хугацаа хоцроосон үйлдэлд санаатай эсвэл хэт болгоомжгүй, 3) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах боломжтой гэдэг агуулгаар тайлбарлах боломжтой.

IV. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны үндсэн хэсэгт Япон Улсын урьдчилсан хэлэлцүүлгийн эрх зүйн зохицуулалт, онол болон практикийн түвшинд тулгамдаж буй асуудлыг 1996 оноос өмнөх, дараах гэсэн агуулгаар авч үзсэн. Сайн туршлагыг харгалзаж үзэн гэдэг нь зөвхөн тухайн улсын ололт амжилт бус алдаа дутагдлыг ч мөн анхаарахыг хэлдэг. Тиймээс судалгааны 3 дахь хэсэгт тус улсын алдаа дутагдал, ололт амжилт болон өөрийн орны иргэний процессын эрх зүйн онцлогийг харгалзан урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэхтэй холбоотой анхаарах зарим асуудлыг дэвшүүлсэн.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай явуулахад урьдчилсан хэлэлцүүлэг чухал ач холбогдолтой боловч үүнийг хэлбэр төдий бус, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай. Тодруулбал шүүх болон хэргийн оролцогч нарын хамтын ажиллагаа чухал юм. Иймд шүүхийн тодруулах эрх ба түүний хүрээ хязгаар, шүүгчийн түр зуурын дотоод итгэл үнэмшил, мөн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хугацааны талаар цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
2. 民事訴訟法 (1996年)。
3. 民事訴訟規則 (1996年)。
4. 裁判の迅速化に関する法律 (2004年)。

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Б.Хонгорзул. "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг нэвтрүүлэх нь". <https://legaldata.mn/b/745>. 2018 он.
2. Бат-Эрдэнийн Буянхишиг. Э.Отгонзул зэрэг, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: хэргийн оролцогчийн эрх ба иргэний хэргийн хойшлолт". <https://legaldata.mn/b/827>. 2019 он.
3. Монгол Улсын дээд шүүх, "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хугацаа хэтэрсэн болон түдгэлзүүлсэн хэргийн судалгааны тойм", https://supremecourt.mn/media/files/20220/0_1642583446.pdf. 2019 он.
4. Нямсүрэнгийн Норовсамбуу Б.Хонгорзул. "Улсын дээд шүүхээс иргэний хэргийн шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан үндэслэлд хийсэн дүн шинжилгээ" Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ (4). 2020 он.
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн. "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ". <https://sudalgaa.gov.mn/ddDrTh>. 2021 он.
6. Шүүхийн академи. "Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн талаарх харьцуулсан судалгаа". <https://legaldata.mn/b/2545>. 2022 он.



3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

1. 三ヶ月章「わが国の準備手続制度の問題点」『民事訴訟法研究〈第三巻〉』（有斐閣・1966年）。
2. Rolf Bender（シュトットガルト高裁判事）《木川統一郎と伊藤 瑩子》）訳「訴訟促進：日本の雑誌「ジュリスト」に寄せて」ジュリスト 477 号（1971年）。
3. 林屋礼二『明治期民事裁判の近代化』（東北大学出版会・2006年）。
4. 福田剛久「当事者主義と職権主義の間で」判例タイムズ 1317 号（2010年）。
5. 松村和徳『手続集中論』（成文堂、2019年）。
6. 早稲田大学『日本法の中の外国法—基本法の比較的考察（早稲田大学比較法研究所編 41）』（成文堂・2014年）。
7. 斎藤秀夫ほか筆者代表『注釈民事訴訟法（4）』（第一法規出版株式会社・1975年）。
8. 沢栄三「民事における集中審理の経験」法曹時報 23 巻 6 号（1971年）。
9. 司法研修所編『準備手続の実務上の諸問題（第 1 版）』（法曹会・1989年）。
10. 三ヶ月章『民事訴訟法〈補正版〉』（有斐閣・1981年）。
11. 門口正人ほか『裁判官の観点 民事裁判と専門訴訟』（商事法務・2018年）。
12. 鈴木正裕「弁論兼和解方式について」民事訴訟雑誌 36 号（1990年）。
13. 柳田幸三「新民事訴訟法について」ジュリスト 1098 号（1996年）。
14. 司法研修所監修『4 訂民事訴訟第一審手続の解説【事件記録に基づいて】』（法曹会・2001年）。
15. シンポジウム「民事裁判手続に関する運用改善提言」判例タイムズ 1492 号（2021年）。
16. 三木浩一ほか『民事訴訟法（第 4 版）』（有斐閣・2023年）。
17. 安西明子ほか『民事訴訟法（第 3 版）』（有斐閣、2023年）。
18. 2023 年 6 月 20 日に、竹内幸伸裁判官、上松健太郎弁護士（いずれも名古屋大学大学院法学研究科実務法曹養成専攻実務家教員 准教授）に対して行った争点整理手続の実務に関するヒアリングによる。
19. 伊藤真『民事訴訟法への招待』（有斐閣・2022年）。
20. 山本和彦『民事裁判手続の IT 化』（弘文堂・2023年）。
21. 新堂幸司『新民事訴訟法（第 6 版）』（弘文堂・2019年）。
22. 法務省民事局参事官室『一問一答新民事訴訟法』（商事法務研究会、1996年）。
23. 垣内秀介「民事訴訟の審理をめぐる問題状況」論究ジュリスト 24 号（2018年）。
24. 鼎談「裁判迅速化検証の 20 年とデジタル世代につなぐ理念—民事訴訟を中心に—」判例タイムズ 1512 号（2024年）。
25. 裁判の迅速化に係る検証に関する報告書（第3回）」27頁、2009年<https://www.courts.go.jp/vc-files/courts/file2/20507002.pdf>。
26. 最高裁判所事務局「裁判の迅速化に係る検証結果の公表（第 10 回）について」判例タイムズ 1512 号（2023年）。
27. 「裁判の迅速化に係る検証に関する報告書（第11回）」47頁、2025年https://www.courts.go.jp/vc-files/courts/2025/11_houkoku_3_minji.pdf。。

4.Цахим эх сурвалж

1. Япон Улсын эрх зүйн хэм хэмжээний хайлтын цахим хуудас: <https://laws.e-gov.go.jp/>
2. Япон Улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.courts.go.jp/saikosai/>



Article

The Development Of Pre-Trial Conferences In Japanese Civil Procedure Law: Best Experiences

ERKHBILGUUN Erdenebaatar*

Abstract: This article examines the historical development and legal regulation of pre-trial conferences as a stage of civil proceedings in Japan, with the aim of clarifying several issues that should be considered when introducing pretrial conferences into Mongolia's civil procedure system. In particular, Japan first introduced the pre-trial conferences in the Code of Civil Procedure of 1925 in order to reduce delays in civil litigation. Although amendments were made in 1948, 1950, and 1956 improve their effectiveness, these reforms did not produce the expected results.

However, the Code of Civil Procedure enacted in 1996 introduced a litigation process focused on the issues in dispute, with the pretrial conference serving as its central mechanism. Since the new law came into force, delays in civil proceedings in Japan have been reduced to a certain extent. Furthermore, the 2022 amendments made it possible to conduct pretrial conferences in an online format, and practical reforms are currently being implemented to address issues arising in the operation of pretrial conferences.

Keywords: issue, relevant evidence, social procedure law, issue-focused proceedings, examination of evidence

* Head of the Constitutional and International Law sector, Judicial academy under the Supreme court of Mongolia.